

01 дүгээр сарын үйл ажиллагааны мэдээ**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар**

Аймгийн ИТХ-ын дарга Д.Хосбаяраар ахлуулсан ажлын хэсэг суманд 1 хоног ажиллаж төсөвт 5 байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж, сум орны өвөлжилтийн бэлтгэл ажил болон цаг үеийн ажлуудын талаарх мэдээлэл, тулгамдаж буй асуудлуудыг сонсож аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг танилцуулж төрийн албан хаагчид, байгууллагын дарга эрхлэгч нартай нийт 25 төрийн албан хаагчтай уулзалт хийж санал бодлыг сонслоо. Аймгийн төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр болон сургалтын хөтөлбөр төлөвлөгөөний биелэлт төрийн албаны томилгоо, төрийн албаны сул орон тоог нөхөх талаар болон төрийн албаны хуулийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлтийг үзэж шалгаж заавар зөвлөгөө өгч ажилласан.

Сумын засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг Аймгийн Засаг даргын 2021 оны А/26 тоот захирамжийг хэрэгжилтийг хангах ажлыг ЕБС, дотуур байрны бэлтгэл бэлэн байдал халдвар хамгааллыг хийж гүйцэтгэсэн байдалд хяналт шалгалт хийлээ.

Шалгалтаар 8 ангид 7 хичээлийн 44 хүүхэд хичээл хийх бэлтгэл ажил хангагдсан байна. Сургууль руу ороход үүдэнд өдөр бүр багш нар хуваарийн дагуу халуунийг хэмжиж, бүртгэл хөтлөх бүртгэлийг гаргаж, ковидын зай барих сэрэмжлүүлэгийг байршуулсан байна. Сургуулийн дотуур байранд эрэгтэй 3, эмэгтэй 6 нийт хүүхдийг хүлээн авах бэлтгэл бэлэн байдал хангагдсан гэж дүгнэлээ.

Ковид -19 цар тахлын хүрээнд: 2020 оны 01 сарын 28 ны байдлаар гэрийн ажиглэлтэнд нийт 51 үүнээс хүүхэд -10, насанд хүрэгчид 40, ажиглалтаас -1 гарч, нэмэгдсэн 6 хүн байна. 1 сарын 26 ны татан авалтаар 20 иргэн ирснийг гэрийн ажиглалтанд авч хяналтыг хийж байна. Сумын хэмжээнд худалдаа үйлчилгээ эрхэлдэг 31 дэлгүүр, аан, ШТС-2, банк -2-т хүүхдийн цэцэрлэгийн албан хаагчид ариутгал халдваргүйтэл, зай барих, маск зүүж үйлчлүүлж байгаа мөн бүртгэл хөтлөлт QRкодыг уншуулж байгаа зэрэгт хяналт шалгалтыг хийж ажилласан. Зөрчил илрээгүй холбогдох аж ахуйн нэгжүүд шаардлагыг биелүүлж ажиллаж байна.

Эдийн засаг, төсөв санхүүгийн хүрээнд: 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тушаах ажил, төрийн сангийн тайлан тушаах, ААНОАТ тайлан, цалингийн ашгийн талан, ХХОАТ тайлан, тушаах, хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдсан иргэдэд заавар зөвлөгөө өгч, ЗДТГ-ын албан хаагчдад ХХОАТ хийх талаар сургалт зохион байгуулсан. Нийт 15 төрийн албан хаагч хамрагдсан. 2021 оноос хэрэгжиж буй малын тоо толгойн албан татварын хувь хэмжээг тогтоох талаар санал асуулга иргэдээс авч нэгтгэн ИТХ-д оруулж батлуулсан. Сум хөгжүүлэх сангийн зээл олгох зөвлөл болон хяналтын зөвлөлийг ИТХ-аар шинэчлэн батлуулсан

Дөрөв. Нийгмийн бодлогын хүрээнд:

Соёл урлагийн чиглэлээр Улсын онцгой комиссын шийдвэрээр өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор олон нийтийн арга хэмжээг хорьсон учир зохион байгуулагдаагүй.

Байгууллага дээр хариуцлагатай жижүүр гаргаж ариутгал халдваргүйжүүлэлт бусад арга хэмжээг ханган ажиллаж байна.

Цахимаар цар тахалтай холбоотой мэдээ мэдээлэл 15, соёл урлагийн мэдээ мэдээллийг 12 удаагийн давтамжтайгаар хүргэн 520 иргэдийн хандалт авч ажилласан. Байгууллагын ажилтнуудын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж Соёлын төвийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, 2021-2024 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг тус тус боловсруулан сумын Засаг даргаар батлууллаа. Байгууллагын ажилтнуудыг чадавхижуулах зорилгоор гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй, төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, сургалтын хэрэгцээ, эцэг эхийн зөвлөл ажиллуулах тухай сэдвүүдээр хамтарсан сургалтуудыг дотооддоо зохион байгуулж сургалтанд нийт 8 ажилтан хамрагдсан.

Халамжийн чиглэлээр: 2017-2020 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрт хамрагдсан нийт 26 иргэний 117,000,000 төгрөгийн эргэн төлөлтийн тооцоо нийлсэн актыг иргэнтэй тулган баталгаажуулахаас 17 иргэний тооцоог батлгаажуулан гарын үсэг зуруулаад байна.

Шинээр энэ сард 2 ажлын байр бий болсон байна. ЗДТгазарт – Угтах үйлчилгээний ажилтан, Нийтийн биеийн тамирын арга зүйч гэсэн 2 шинэ ажлын байр бий болсон.

Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийг энэ сарын 13, 23-нд хуралдуулж асаргаа шинээр тогтоолгох 4 иргэний хүсэлт, асаргаа сунгах 7 иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.

Нийгмийн халамжийн сангийн олголт 357 иргэнд 36,260,070 сая төгрөгийн олголт хийсэн.

Насны хишиг шинээр авах эрх үүссэн 65 нас хүрсэн 6 иргэнд мэдээлэл хүргэж өргөдлийг хүлээн авч e halamtj системд бүртгэлээ. Мөн хувийн хэргийг WAIS программтай тулгалт хийж ажилласан. Нийт 199 иргэний хувийн хэрэгт тулгалт хийсэн. Алдарт эхийн одонгийн 1-р одонтой 164 эх, Алдарт эхийн 2-р одонтой 275 эх, нийт 439 эхийн мэдээллийг тулган дансжууллаа..

Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийг 1 сарын 20-нд хуралдуулж асаргаа сунгах 6 иргэний хүсэлт, тэжээгчээ алдсны 1 иргэн, Түлээ нүүрсний хөнгөлөлт авах 1 ахмад настны хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн.

Эрүүл мэндийн чиглэлээр: Амбулаторийн үзлэг 365 үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 152 байна.

Тусгаарлах эмчлэх байрны бүс бүрт байх тоног төхөөрөмж эд материалын нэрсийг гаргаж бүс бүрт байршуулсан. Сэжигтэй тохиолдлын үед бүсэд байх шаардлагатай эд материал тоног төхөөрөмжийг байршуулах ажлыг эзэнжүүлсэн.

Эмч, эмнэлгийн ажилтан бүрийг нэг удаагийн хамгаалах хувцас өмсөх, тайлах дараалалын дадлага сургуулилалт хийх хуваарь гарган, хяналтын хуудсаар үнэлэн, гарын үсэг зуруулж дадлага хийлгэж байна.

Хэвтэн эмчлүүлэгчдийн журамд нэмэлт тодотгол оруулж эргэлт болон сахиурт журмыг хэвтэн эмчлүүлэгчдэд, эргэлтийн болон бусад үйлчлүүлэгчдэд танилцуулах зорилгоор 2% гаргаж байршуулсан.

- Их цэвэрлэгээг сард 2 удаа хийдэг бөгөөд шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүй хийж ХХБаг хяналтын хуудсаар үнэлж байна.
- Гэрийн тусгаарлалт ажиглалтыг ЕБСургуулийн багш 5 багт нийт 23 багшид сургалт зохион байгуулж гэрийн тусгаарлалт ажиглалтыг хүлээлгэн өгч ЭМТөвөөс хяналт хийн ажиллаж байна.

Гэрийн ажиглалтанд 12 хүнийг авч өдөр бүр хяналтын хуудсаар хянаж байна. Энэ сард ЭМТөвөөр нийт 953 хүн үйлчлүүлсэн. Эдгээр иргэдийн халууныг үзэж зөвлөгөө өгч ажиллалаа.

ЭМТ-ийн тусгаарлах хэсгийн завсрын бүсийг өргөтгөж шаардлагатай бүх зүйлсийг байршуулсан. Ногоон бүсийг шинээр тогтоож хаалга гаргасан.

Түргэн тусламжийн дуудлага 92 ирснээс алсын дуудлага -8 ойрын дуудлага 84 ирсэн байна.

Тав: Мал эмнэлэгийн болон ХХАА-н чиглэлээр:

ХАА: 2021 оны арьс ширний урамшуулалд 750 иргэний Адуу 3, үхэр 2319 арьс шир, хонь ямааны 13146 арьс дотоодын үйлдвэрт тушааж падаан бичиж шивэлт хийж холбогдох газарт хүргүүлсэн. 2020 онд мал аж ахуйн салбарт амжилт гаргасан 6 малчин үүнээс улсын аварга малчинд 1, аймгийн аварга малчинд 4 алтан төлд 1 малчдын материалыг аймгийн ХХААГ-т хүргүүлж ажилласан.

МЭТ: Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нартай хамтарч 8 дэлгүүрээр орж 206 нэр төрлийн 43,8 кг хиам, 274 ш хүнсний хугацаа хэтэрсэн хадгалалтын горим алдсан хаяг шошигний зөрчилтэй 1101590 мян төгрөгний бүтээгдэхүүн хураан авсан. Сумын төвийн тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгжээр архины хяналт хийж ажилласан. Статистикт МЭ-1 мэдээг хүргүүлсэн. Хувийн хэвшлийн 5 мал эмнэлгийн ажлыг засаг даргын зөвлөлөөр дүгнүүлж ажилласан. Жилийн эцсийн тайлан мэдээг цаг хугацаанд нь хүргүүлсэн.

Зургаа : Байгаль орчин газар зохион байгуулалтын чиглэлээр:

Сумын төвд нэгдсэн хогны машин маршрутын дагуу явж байна. 2021 онд хийх ажлын төлөвлөгөөг гаргаж Тамгын газрын даргаар батлуулсан. Сумын төв тойрсон эзэнгүй хог хаягдалд 1 удаа 4-р багийн засаг даргын хамт хяналт тавьж ажилласан. Үүнд 10 л түлш зарцуулсан. Газрын кадастрын системд 13 иргэний газар өмчлөх өргөдлийг цахимаар хүлээн авч ажиллаа. Үүнд:

- Шинээр газар эзэмших -3
- Төрөөс нөхөн олговортойгоор эргүүлэн авах-9
- Худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр газар өмчилж авах-1

Мөн 17 иргэнд 32 кадастрын үнэт цаасаар үйлчилж, 9 иргэний газар өмчлөх эрхийн гэрчилгээг улсын бүртгэлд захиалж өгөөд байна.

Газрын цахим бирж программд өдөр тутам нэвтэрч барьцаа болон үнийн мэдээг цуглаан бүртгэж ажиллаж байна. ЛМ цахим программд өргөдөл бүртгэх үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.

ГХБХБГазар, БОАЖГазар хамтран 2021.01.14-ны өдрийн сумын иргэдийн төлөөлөгчдийн ээлжит бус IV–р хуралдаанаар 172855.7164 га газрыг тусгай хэрэгцээнд авах тухай хэлэлцүүлэн тус өдрийн А/08-А/24 тоот тогтоолуудаар отрын нөөц нутаг, хадлан тариалангийн газар, тусгай хэрэгцээний газар зэргийг батлууллаа.

2021.01.20-ны өдрийн А/20 тоот захирамжаар 4 байршилд дуудлага худалдаа зарлан цахим биржид зураг, байршлыг бүртгэн зарыг оруулаад байна.

- 2108: Нам, олон нийтийн байгууллага-872
- 2108: Нам, олон нийтийн байгууллага-600
- 1602: Мал эмнэлгийн үйлчилгээний цэг-2000
- 1606: ХАА-н үйлдвэрлэлийн цогцолбор-5996

Web систем дээр 45 нэгж талбарт газрын төлбөрийн ногдуулалт хийж, 90 нэхэмжлэх үүсгэн ажиллаж байна. Одоогийн байдлаар 2 иргэн төлбөрийн төлөлтийг хийгээд байна.

МЭДЭЭ НЭГТГЭСЭН: ТГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН

О.ТУЯА.